

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /10-р сарын 02-нөөс 10-р сарын 30-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	X/02	X/09	X/16	X/23	X/30
1	Гурил, I зэрэг, кг	700	700	700	700	700
2	Хонины мах, кг/ ястай/	6500	6500	6500	6500	6500
3	Үхрийн мах, кг /ястай/	7500	7500	7500	7500	7500
4	Ямааны мах /ястай /	6000	5700	6000	5500	5500
5	Элсэн чихэр, кг	1550	1550	1550	1550	1550
6	Цагаан будаа, кг	2000	2100	2100	2100	2100
7	Шингэн сүү, л	900	900	1000	1000	1200
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан					
9	- Бор ноолуур					
10	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1550
11	Бензин, А-92, 1 литр	1650	1650	1650	1650	1650
12	Дизелийн түлш, 1 литр	1750	1750	1750	1750	1750

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2013 оны 10-р сарын 02-ноос 10-р сарын 30-ны хооронд ямааны ястай мах, цагаан будаа, шингэн сүүний үнэ өөрчлөгдөж бусад бүтээгдэхүүний үнэ тогтвортой байв. Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийгдсэнгүй.

Махны үнэ. Хонь, үхрийн ястай мах сүүлийн 5 долоо хоногийн туршид өөрчлөгдөөгүй. 1 кг ямааны ястай мах 10-р сарын 2, 16-нд 6000 төгрөг байсан бол 10-р сарын 9-нд 5700 төгрөг, 23, 30-нд 5500 төгрөг болон 10-р сарын 2-ны ханшаас 5-8,3%-аар буурав.

Цагаан будаа. 1 кг цагаан будааны дундаж үнэ 10-р сарын 2-нд 2000 байсан бол 10-р сарын 9-нөөс 5,0%-аар өсч 2100 төгрөгийн ханштай болов.

Шингэн сүү. Хүйтний улирал ирж буйтай холбоотойгоор шингэн сүүний нийлүүлэлт багасч үнэ нь өсч байна. 10-р сарын 2, 9-нд 1 литр сүү 900 төгрөг байсан бол 16, 23-нд 1000 төгрөг болж 100 төгрөгөөр өсөв. 10-р сарын 30-ны мэдээгээр өмнөх 7 хоногийн үнэнээс 20% -аар өсч 1200 төгрөг болов.



